



PARIS2015
UN CLIMATE CHANGE CONFERENCE
COP21·CMP11



НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Талуудын 21 дүгээр Бага хурлын тухай танилцуулга

**Н.БАТЦЭРЭГ,
БОНХАЖ-ЫН САЙД**

АГУУЛГА

1

- Дэлхийн болон Монгол орны уур амьсгалын өөрчлөлт

2

- НҮБУАӨСК, Талуудын Бага Хурал

3

- Талуудын 21 дүгээр Бага Хурлын онцлог

4

- Парисын гэрээ

5

- Монголын төлөөлөгчдийн оролцоо

6



- Цаашид хийх ажил

Дэлхийн уур амьсгал дулаарсаар байна!

Дэлхийн газар болон далайн гадаргын дундаж температур, 1850-2012



Гадаргуун температурын өөрчлөлт
1901-2012




“...дэлхийн агаарын дундаж температурын өсөлтийг 2°C-аар хязгаарлахын тулд дэлхий нийтээр хүлэмжийн хийн ялгарлыг огцом сааруулах шаардлагатай тулгарч байна” (UNFCCC, 2010)


"Climate Central" судалгааны байгууллагын тооцоолсноор дэлхийн дулаарлын эсрэг тууштай арга хэмжээ аваагүй тохиолдолд энэ зууны эцэст дэлхийн дулаарлын өсөлт 4 хэмд хүрснээр далайн түвшин 8.9 метрээр нэмэгдэж, нийт 627 сая хүн усанд автах аюултай. Харин дулаарлыг 2 хэмд хязгаарлавал энэ тоог 280 сая болгон бууруулах боломжтой юм" гэж мэдэгдлээ.

Уур амьсгалын өөрчлөлт: Монголд

- Сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд манай орны агаарын жилийн дундаж температур 2.1 градусаар дулаарсан
- Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн 10 жилд гамшигт үзэгдлийн давтамж 1.5 дахин нэмэгдэж, улам эрч хүчтэй тохиох болсон
- Сүүлийн 12 жилд ус цаг уурын гамшигт үзэгдлийн улмаас 424 хүний амь нас эрсдэж, 24.5 сая мал хорогдож, олон тэрбум төгрөгийн хохирол учирсан
- Монгол Улс УАӨ-ийн урт хугацааны эрсдэлийн индекс гэсэн үзүүлэлтээр дэлхийн хамгийн өндөр эрсдэлтэй 10 орны 8 дугаарт жагсаж байна



Монгол орны жилийн дундаж агаарын температурын өөрчлөлт, °C 1940-2014 он



Монгол оронд жилд ажиглагдсан аюултай болон гамшигт үзэгдлийн давтамж

НҮБ-ЫН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУУРЬ КОНВЕНЦ- МОНГОЛ УЛС

Монгол Улсын Засгийн газар УАӨ-ийн асуудалд анхаарал хандуулж идэвхтэй оролцдог

- УИХ Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц /НҮБУАӨСК/-ийг 1993 онд
- Киото протоколыг 1999 онд соёрхон баталсан

НҮБУАӨСК-ын хэрэгжилтийн хүрээнд

- Үндэсний анхны илтгэлээ 2001 оны 11 сард
- Хүлэмжийн хийн ялгарал /ХХЯ/-ыг бууруулах зохистой арга хэмжээний жагсаалтыг /НАМА/ 2010 оны 01 сарын 28нд
- Үндэсний 2 дахь илтгэлээ 2010 оны 12 сарын 10нд хүргүүлсэн
- Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг 2000 онд, 2011 онд шинэчлэн баталсан
- ХХЯ-ыг бууруулах болон дасан зохицох Технологийн хэрэгцээний үнэлгээг 2013 онд боловсруулсан
- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмрээ /INDC/ 2015 оны 9 сард хүргүүлсэн

Одоогоор хийгдэж байгаа ажлууд

- Үндэсний 3 дахь тайлан илтгэлээ боловсруулж байгаа
- ХХЯ-ын тооллогын 2 жил тутмын тайланг гаргахаар ажиллаж байна.




НҮБ-ЫН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУУРЬ КОНВЕНЦИЙН ТАЛУУДЫН БАГА ХУРАЛ


НҮБУАӨСК-ийн хэрэгжилтийг дэмжих, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Талуудын Бага Хурал /COP/-ыг жил бүр зохион байгуулдаг.

“Конвенцийн үндсэн зорилт нь уур амьсгалын системийг аюултай түвшинд хүрэхээргүйгээр хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг тогтворжуулах юм.”

Дэлхийн ХХЯ




www.ec.gc.ca/indicators/indicators



Монгол орны ХХЯ

2012 оны байдлаар хүлэмжийн хийн ялгарал /ХХЯ/ 26 сая тонн CO₂-экв байна.



COP21-ИЙН ӨМНӨ БҮРДҮҮЛСЭН НӨХЦӨЛҮҮД

- Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр батлагдсан. Түүний 13 дугаар зорилго-УАӨ-ийн эсрэг хариу арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх /5 зорилт дэвшүүлсэн/
- COP17-оос гарсан Шинэ гэрээ хэлэлцээр боловсруулах ажлын хэсгийг сайн ажилласан гэж дүгнэсэн



Бали
2007

Копенгаген
2009

Дурбан 2011

Варшав
2013

Лима
2014

Парис
2015

COP 13

COP 15

COP 17

COP 19

COP 20

COP 21

ХХЯ-ыг
бууруулах
зохистой
арга хэмжээг
тодорхойлох

Конвенцийг
дороос дээш
чиглэсэн
хандлагаар
хэрэгжүүлэх

Durban
platform -олон
улсын шинэ
хэлэлцээр
байгуулахаар
тохирсон

Хэлэлцээрт
оруулах улс
орнуудын хувь
нэмрийг
тодорхойлох
шийдвэр
(INDCs)

УАӨ-ийн талаар
авах арга
хэмжээг
эрчимжүүлэх
тухай Лимагийн
уриалга

Олон улсын
хэлэлцээр-
Парисын
гэрээ

Талуудын 21 дүгээр Бага хурал (COP 21)-Онцлог

Дэлхийн 195 улс уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хэлэлцээрт хүрсэн. Бүгд хүлээн зөвшөөрсөн хэлэлцээр дэлхийн түүхэнд байгаагүй томоохон арга хэмжээ боллоо гэж олон улсын мэдээллийн агентлагууд мэдээлсэн.

- Улс төрийн хувьд бүх улсын удирдагчид /АНУ, Хятад, Япон г.м/ УАӨ-ийн эсрэг хариу арга хэмжээнд хамтын хүчээ нэгтгэхийн чухлыг онцолсон
- Хятад, Энэтхэг зэрэг аж үйлдвэржсэн томоохон орнууд өмнө нь үүрэг амлалтаа бэлтгэж байгаагүй. Энэ удаад бүгд танилцуулсан.
- Франц Улс манлайллыг гартаа авч Парисын гэрээг батлахад ихээхэн хүчин чармайлт гаргасан
- Хөгжингүй, хөгжиж байгаа ялгаагүй бүх улс орон дагаж биелүүлэх **Парисын гэрээ** баримт бичгийг батлан гаргалаа.
- **187** улс ХХЯ-ын бууруулахад оруулах хувь нэмрээ /INDC/ тодорхойлон Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн
- Олон улсын эрчим хүчний агентлагийн мэдээлсэнээр дэлхийн 195 улс 2030 он хүртэл УАӨ-ийн эсрэг 16,5 их наяд ам.доллар зарцуулах тохиролцоонд хүрчээ гэж дүгнэсэн байна.



ПАРИСЫН ГЭРЭЭ

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудалд хөгжингүй, хөгжиж байгаа ялгаагүй **бүх улс орон дагаж биелүүлэх баримт бичиг**
- УАӨ-ийг бууруулах **урт хугацааны зорилтыг тодорхойлсон**
 - ХХЯ-ыг бууруулж дэлхийн дулаарлын хэмжээг **2°C-аас доош** түвшинд хязгаарлах, цаашид **1.5°C-т барихын төлөө** бүх улс орон чармайн ажиллах шаардлагатай гэж заасан
- Парисын Гэрээ албан ёсоор 2020 оноос хэрэгжинэ
 - Дэлхийн нүүрсхүчлийн хийн **ялгарлын 55 хувийг бүрдүүлдэг улс** орнууд хэлэлцээрийг тус бүр баталсны дараа хүчин төгөлдөр болно
- Парисын гэрээ баримт бичигт гарын үзэг зурах Дээд хэмжээний арга хэмжээг **2016 оны 4 сарын 22-ны өдөр Нью-Йорк хотноо зохион байгуулна**

ПАРИСЫН ГЭРЭЭ

- УАӨ-д дасан зохицох асуудал
 - УАӨ-д **дасан зохицох**, түүний чадавхийг нэмэгдүүлэх, дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах
 - **2020 он хүртэл дасан зохицох асуудалд санхүүжилтийг эрс нэмэгдүүлэх**
 - Болзошгүй гамшгаас учрах алдагдал эвдрэлийг тооцох, хариуцлага хүлээлгэх асуудлыг тусгах
- Санхүүжилтийн асуудал
 - Хөгжиж байгаа орнуудад жил бүр **100 тэрбум ам.долларын** санхүүжилтийг **2025 он хүртэл олгох**
 - **ХХЯ-ыг бууруулах болон УАӨ-д дасан зохицох асуудалд санхүүжилт, хөрөнгө оруулалтыг тэнцвэртэй байлгах**
 - Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн болон дэмжлэгт хамрагдсан бүх улс орнууд **санхүүтэй холбоотой тайлангаа сайжруулах**
- Технологи дамжуулалт
 - Дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, дамжуулах нь хэрэгжилтийг хангах гол хүчин зүйл бөгөөд хөгжиж байгаа улс оронд холбогдох дэмжлэгийг үзүүлэх
- Дэлхийн хэмжээгээр нэгтгэсэн дүн гаргадаг болно
 - ПГ хэрэгжиж эхэлсэнээс хойш **Үндэсний зорилтот хувь нэмрийг 5 жил тутамд тайлагнаж, олон улсын хяналт хийх**
- Парисын гэрээний хүрээнд ЗГ-ууд **байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, сэргээгдэх эрчим хүчний салбарыг дэмжиж, хатуу түлшний хэрэглээг бууруулахад анхаарах**
- Үүнээс гадна нүүрсхүчлийн хийг ямар хэмжээгээр бууруулах зорилтоо ЗГ өөрсдөө тогтоож **болох ч олон улсад тайлагнах зарчим нь хууль ёсны дагуу, нээлттэй байх шаардлагатай**
- **Парисын гэрээний хүрээнд олон улсын хамтын ажиллагаа шинэ шатанд гарч аюулаас зайлсхийхийн хамт ахиц дэвшил, ашиг орлого ярих бололцоо гарна гэж дүгнэсэн**

COP21-Монголын төлөөлөгчдийн оролцоо

COP21-ийн нээлтийн өдөр буюу 11 дүгээр сарын 30-нд дэлхийн улс орнуудын төр засгийн тэргүүн нарын оролцсон “Удирдагчдын уулзалт” арга хэмжээнд МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцож үг хэлсэн.



COP21-Монголын төлөөлөгчдийн оролцоо

COP21-ийн дээд хэмжээний хуралдаан 12 сарын 7-8-ны өдрүүдэд болж 130 гаруй орны сайд нарын түвшний төлөөлөгчид оролцов. Дээд хэмжээний хуралдаанд БОНХАЖ-ын Сайд Н.Батцэрэг оролцож үг хэлэв.



COP21-Монголын төлөөлөгчдийн оролцоо

Орон нутгийн оролцоо:


COP21-ийн үеэр Парис хотноо орон нутгийн удирдлагад зориулсан тусгай арга хэмжээнүүд зохион байгуулж хурлын үеэр УАӨ-д хотуудын оруулах хувь нэмэр, эргээд хот суурин газар УАӨ-д хэрхэн өртөх, түүнээс сэргийлэх талаар хэлэлцүүлэгүүд өрнөсөн. Эдгээр арга хэмжээнд ийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагч Э.Бат-Үүл тэргүүтэй төлөөлөгчид оролцсон.

COP21- Монголын төлөөлөгчдийн байр суурь

Хэлэлцээрийн хүрээнд дараах байр суурьтай оролцсон:

- дэлхийн бүх улс орнууд дагаж мөрдөх баримт бичиг гаргах шаардлагатай гэдэгт санал нэгдсэн
- Хэлэлцээр нь ялгаваргүй, УАӨ өндөр эрсдэлтэй орнуудад илүү анхаарал хандуулах ёстой гэж үзсэн
- Урт хугацааны зорилтыг хэрэгжүүлэх гол хүчин зүйл нь хөгжиж байгаа улс орнуудад үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх асуудал гэж үзсэн
Санхүүгийн дэмжлэг нь технологи дамжуулалт болон чадавхийг бүрдүүлэхэд чухал шаардлагатай

Үндэсний зорилтот хувь нэмэр буюу хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломж



- Үндэсний зорилтот хувь нэмрийн баримт бичигт тусгасан ХХЯ-ыг бууруулах дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр 2030 оны үед ХХЯ 7.3 Мегатонн CO₂-экв.-аар буурах ба энэ нь эдийн засгийн хөгжлийн өнөөгийн буюу суурь сценариар тооцсон утгаас 14%-иар буурах магадлалтай.

COP21- Монголын төлөөлөгчдийн байр суурь

МУ нэгдэн орсон УАӨ-д эмзэг орнуудын форумын жинтэй санал:

- Далайн жижиг арлууд болон ган гачаал, үер усны аюул зэрэг байгаль цаг агаарын аюул гамшигт өртөмтгий **20 улс** орныг нэгтгэсэн **“УАӨ-д эмзэг орнуудын форум”**-д энэ хурлын үеэр **Монгол зэрэг 10-аад улс шинээр нэгдэж орсон**. Энэ форумд оролцогч орнууд УАӨ-ын босгыг **2°C** биш **1.5°C** болгох зарчмын шинэ санал **дэвшүүлсэн** бөгөөд бусад хөгжиж байгаа болон хөгжингүй **120 гаруй улс орон** энэ саналыг **дэмжсэн юм**. Энэ нь хэдийгээр боловсруулсан бичиг баримтын төсөлд багагүй өөрчлөлт оруулахад хүргэсэн хэдий ч саналыг Талууд нийтээрээ хүлээн зөвшөөрч Хурлаас батлан гаргасан **Парисын гэрээнд шинэ нэмэлт зорилт байдлаар томъёологдон орсон**.

1.5°C-ын босгыг дэмжиж байгаа байдал



БОНХАЖ-ын Сайдын оролцсон томоохон арга хэмжээ

БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос зохион

байгуулсан **Өмнөд өмнөдийн хамтын ажиллагааны** хэлэлцүүлэгт оролцож үг хэллээ.

- БНХАУ-ын ЗГ-аас энэхүү санаачилгад улс төрийн хүчтэй дэмжлэг үзүүлэхээ зарласан бөгөөд Ерөнхийлөгч Си Жинпин “Хятадын Өмнөд-өмнөдийн уур амьсгалын сан”-г шинээр байгуулж бага нүүрстөрөгч бүхий хөгжлийг дэмжиж 3,1 тэрбум ам.доллар зориулахаа 2015 оны 9 сард мэдэгджээ. Энэхүү сангаар дамжуулан БНХАУ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Японы БОЯ-ны “Хамтарсан Кредит олгох механизм” арга хэмжээнд оролцлоо.

- Японы Байгаль орчны сайд хатагтай Тамаёо Маракуватай уулзаж, Японы NHK телевизэд ярилцлага өглөө.

Францын Гадаад харилцаа, олон улсын хөгжлийн сайд Лаурент Фабиусын хүлээн авалтад оролцлоо.

- Хүлээн авалтын үеэр ноён Лаурент Фабиус, түүний гэргий хатагтай “Flag Renaissance” соёлын нийгэмлэгийн тэргүүн Мариа Франс Маршан Бэйлэ нартай уулзаж аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар Нүүдэлчдийн соёлыг түгээн дэлгэрүүлж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох чиглэлд хамтран ажиллахаар боллоо. Мөн 2016 оны 5 сард Францын соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтов.
- Уругвай, Шри Ланка, Австри, Ирак, Бангладеш, Хятад, Япон улсын сайд нартай уулзаж санал солилцов.



БОНХАЖ-ын Сайдын оролцсон томоохон уулзалтууд

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр /БОХ/-ийн газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Аким Штейнер

- НҮБ-ын БОХ-ийн газраас “Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл”-ийг Монгол улсад үргэлжлүүлэн дэмжихээ илэрхийллээ.



Даян дэлхийн ногоон хөгжлийн хүрээлэн /ДДНХХ-GGGI/-ийн удирдах зөвлөлийн дарга Индонез Улсын Ерөнхийлөгч асан Сусило Бамбанг Юдойоно, Ерөнхий нарийн бичгийн дарга Иво дэ Буртай нартай уулзлаа.

- Монгол Улстай хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлэх хүсэлт тавихын зэрэгцээ саяхан батласан 2015-2020 оны үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд тодорхой санал тусгаж хэрэгжүүлэхээр тогтлоо.



АНУ-ын Төрийн департаментын Уур амьсгалын асуудал хариуцсан орлогч, тусгай элч хатагтай Карен Флоринитай уулзлаа.

- Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чиглэлээр АНУ-аас хөгжиж буй орнуудад үзүүлж байгаа төсөл, хөтөлбөр, санал, санаачлагад хэрхэн хамрагдах талаар санал солилцлоо.
- Хатагтай Карен Флорини АНУ-ын “Цэвэр эрчим хүчний шийдэлийн төв” байгууллагатай холбож хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэхээ илэрхийллээ.



Цаашид хийх ажил

- БОНХАЖ-ын Сайдын айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. Нийт 15 арга хэмжээ төлөвлөсөн.
 - Парисын гэрээг орчуулж, ГХЯ-аар албажуулах /2016 оны 3 сарын 01-ний дотор/
 - Парисын гэрээг ЗГ-т танилцуулж холбогдох шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулах /2016 оны 3 сард/
 - Парисын гэрээ, COP21-ээс гарсан шийдвэрийг олон нийтэд мэдээлэх арга хэмжээ зохион байгуулах
- Парисын гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлд бусад яамдтай хамтран ажиллах
- УАӨ-ийг сааруулах болон дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлэх
- УАӨ-ийн олон улсын санхүүгийн дэмжлэгт хамрагдах төсөл хөтөлбөрт хамрагдах чиглэлээр идэвхтэй ажиллах

Парисын гэрээний батлагдсан төсөл
Монголын төлөөлөгчдийн ширээн дээр,
хурлын даргын алхны хамт



Анхаарал хандуулсан
баярлалаа!

Merci